

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 05 дугаар сарын 18-ны өдөр

№02

Улаанбаатар хот

“Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59-74 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу 2026 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 12:00 цагаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 4 дүгээр хороо, Сөүлийн гудамж-23, Түшиг төвийн 2 давхрын 211 тоот хурлын танхимд хуралдав.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье!

2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн санал хураалтаар “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай” 26/15 дугаартай шийдвэрийг компанийн тухай хуульд нийцүүлэн гаргасан.

Хуралд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хурлыг зохион байгуулах комиссын дарга Т.Цацрал, Тооллогын комиссын дарга Х.Доржзовд, гишүүн М.Алтангадас, “Монгол Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Э.Алтанзул, Хувьцаа эзэмшигч Милленниум Секьюритис Менежмент Лимитед компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Л.Таня, хувьцаа эзэмшигч Э.Золзаяа, хувьцаа эзэмшигч Ж.Энхтунгалаг, хувьцаа эзэмшигч А.Санчирмаа Компанийн үйл ажиллагааны захирал А.Хонгорзул нар оролцож байна. Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдэд хурлын ирцийг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Х.Доржзовд: “Монгол Даатгал” ХК нь нийт 64,132,341 ширхэг хувьцаатай, нийт 287 хувьцаа эзэмшигч байна. Үүнээс өнөөдрийн хуралд “Милленниум Секьюритис Менежмент Лимитед” компани 63,997,215 ширхэг хувьцаатай, Э.Золзаяа 154 ширхэг, Ж.Энхтунгалаг 10 ширхэг, А.Санчирмаа 95 ширхэг хувьцаатай байна. Нийт саналын эрхтэй 63,997,474 ширхэг хувьцаатай буюу 99,7 хувийн ирцтэй байна.

“Компанийн тухай хууль”-ийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцох тухай Тооллогын комиссын анхдугаар тогтоолыг танилцуулъя.

Тооллогын комиссын дарга Х.Доржзовд тооллогын комиссын 26/03 тоот тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: Хурлын ирц хүрсэн учраас хурлаа нээж, Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн тогтоолыг болон уг тогтоолоор баталсан хурлын дэгийг танилцуулъя.

ТУЗ-ийн тогтоол болон хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: Хурлаар хэлэлцэх асуудлын материалыг та бүхэнд урьдчилан хүргүүлсэн. Хурлын дэгийн дагуу өнөөдрийн танилцуулах асуудал бол Төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан Их хэмжээний хэлцлийг батлах тухай асуудлыг танилцуулна уу хэмээн Гүйцэтгэх захирал Э.Алтанзулыг урьж байна.

Гүйцэтгэх захирал Э.Алтанзул: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе,

Монгол Даатгал ХК-ийн өөрийн өмчлөлийн хөрөнгө болох Сүхбаатар дүүргийн 5-р хороо Үндсэн хуулийн гудамжид байрлах эрхийн улсын бүртгэлийн Ү- 2203014323 дугаартай 2676 мкв конторын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг, нэгж талбарын 1460200680 дугаартай газрын хамт 12,000,000,000 /арван хоёр/ тэрбум төгрөгөөр худалдах гэрээ хэлцэл байгуулах зөвшөөрлийг та бүхнээс хүсэж байна.

Уг гэрээ хэлцлийг хийх зорилго нь Компанийн санхүүгийн чадавхыг бэхжүүлэх, мөнгөн урсгалыг тогтворжуулах зорилготой билээ.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: Гүйцэтгэх захирал Э.Алтанзул танд баярлалаа!
Хувьцаа эзэмшигчдээс асуух асуулт байна уу?

Асуулт, хариулт: Хувьцаа эзэмшигч Ж.Энхтунгалаг компанийн бусад үл хөдлөх хөрөнгийн талаар тодруулж, Гүйцэтгэх захирал Э.Алтанзул товч мэдээлэл өгч, компанийн үл хөдлөх хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээллийг Санхүүгийн газраас албан ёсоор хүргүүлэхээр шийдвэрлэв.

Бусад хуралд оролцогчдоос асуулт гарсангүй.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: Хуралд оролцогчдоос асуулт гараагүй учир хурлаа үргэлжлүүлэн тооллогын комиссын дарга Х.Доржзовд санал тоолох ажил дууссан бол саналын дүнг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Х.Доржзовд: Санал тоолох ажил дууслаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын дүн дараах байдалтай байна. Нийт 63,997,474 саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид саналаа өгч хэлэлцсэн бүх асуудлаар 100 хувийн саналаар зөвшөөрсөн байна. Татгалзсан санал байхгүй тул баталсанд тооцов.

Тооллогын комиссын дарга Х.Доржзовд тооллогын комиссын 26/04 тоот тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: Тооллогын комисс шийдвэрээ танилцууллаа. Үүнийг үндэслэж хурлаас гарах шийдвэрийг танилцуулья.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.10 дахь заалт, 87 дугаар зүйл, Компанийн дүрмийн 5.2.5.2 дахь заалт, 2026 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэх нь ТОГТООХ НЬ:


1. Компанийн санхүүгийн чадавхыг бэхжүүлэх, мөнгөн урсгалыг тогтворжуулах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 25/21 дугаартай тогтоолыг үндэслэн, өөрийн өмчлөлийн хөрөнгө болох Сүхбаатар дүүргийн 5-р хороо Үндсэн хуулийн гудамжид байрлах эрхийн улсын бүртгэлийн Ү- 2203014323 дугаартай 2676 мкв конторын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг, нэгж талбарын 1460200680 дугаартай газрын хамт 12,000,000,000 /арван хоёр/ тэрбум төгрөгөөр худалдах гэрээ хэлцэл байгуулахыг үүгээр зөвшөөрсүгэй.
2. Компанийн нэрийн өмнөөс тус хөрөнгийг худалдан борлуулах гэрээ хэлцэл байгуулахтай холбоотой бүхий л гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Э.Алтанзул/-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

Дээрх тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар баталсан болохыг та бүхэнд мэдэгдлээ. Хуралтай холбоотой сайжруулах, анхаарах зүйлс байвал хувьцаа эзэмшигчдийн хурлын комиссын дарга Т.Цацралд хандах, компанийн вэбсайтаар дамжуулан саналаа илгээх, мэдээлэл авахад нээлттэй. Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцож байгаад талархснаа илэрхийлье. Өнөөдрийн хурал хаасныг мэдэгдье.

Хурал 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 13:00 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА:



Т.Цацрал

Ч.Одонгэрэл